

29. ОГБА. Ф.Миссия в Пекине, ХХ.460, х.159.
30. Мөн тэнд, Ф.Канцелярия министра, хх. 107, х338
- 31."Жунгуо бао", 2.II.1911.-мөн тэнд, Ф.Миссия в Пекине, хх. 107, х.138-139.
32. И.Я.Коростовецоос Цин ноёнд 1911 оны 9-р сарын 11-нд явуулсан захидлын хуулбар. - Мөн тэнд, х.11
33. Цин ноёноос Бээжин дэх оросын элчинд 1911 оны 9-р сарын 11-нд явуулсан захидлын хуулбар. -мөн тэнд, х.11
34. И.Я.Коростовецоос А.А.Нератовт 1911 оны 9-р сарын 19-нд явуулан нууц цахилгаан.- мөн тэнд. Ф.Китайский стол, хх. 135, х. 101.
35. М.С.Князеваас Сайд нарын зөвлөлд 1911 оны 9-р сарын 21-нд явуулсан нууц захидал., -мөн тэнд, х. 138.
36. И.Я.Коростовецоос А.А.Нератовт 1911 оны 10-р сарын 3-нд явуулсан нууц цахилгаан. - мөн тэнд, Х.137.
37. Гүн С.Л.Владиславович-Рагузинский 1727 онд Хиагтын гэрээнд гарын үсэг зурсан.

**"Восток" сэтгүүлийн 1995 оны №1-ээс орчуулсан Д.Шүрхүү**

**Зүүн Хойд Азийн Байгалийн хийн  
хоолойн тухай**

*Доктор Ц.БАТБАЯР*

**1. Хүйтэн дайны дараа үеийн Зүүн Хойт Ази**

"Хүйтэн дайн" төгсгөл болсноор дэлхий нийтийг хамарсан хоёр эвсэл, хоёр системийн хооронд дайн гарах аюул үгүй боллоо. ЗХУ задарснаар Евразийн газрын зурагт зарчмын өөрчлөлт гарч шинээр тусгаар тогтносон 15 улс хуучин Зөвлөлтийн буурин дээр өрх гэрээ засаж байна.

АНУ, Орос хоёр харилцан дайсагналцахаа больж том хэмжээний мөргөлдөөн гарах үүд хаагдлаа. Орос, Хятадын хилийн дагуу цэргийн сөргөлдөөн арилж харилцан итгэлцэх хэлбэрт шилжиж байна.

Гэвч Ази "хүйтэн дайны" өвөөс бүрэн ангижирсан гэж хэлэхэд учир дутгадалтай. "Хүйтэн дайны" Ази дахь гол бүтээгдэхүүн болох Солонгосын хойгийн хуваагдмал байдал хэвээр байна. Орос-Японы хооронд газар нутгийн асуудал шийдэгдээгүй хэвээр, өнөөг хүртэл энхийн гэрээ алга байна. БНХАУ-Тайваны хооронд ч хэрхэн нэгдэх талаар зарчмын зөрчил гүнзгийрсээр байна. Түүн дээр Орост улс төрийн байдал ужиг тогтворгүй хэвээр байна.

а/Орос-Хятадын харилцаа 1990-ээд онд маш эрчимтэй хөгжих замдаа

орлоо. Оросын ерөнхийлөгч Б.Ельцин 1992 онд Бээжинд, БНХАУ-ын дарга Зян Зэмин 1994 онд Москвад айлчилснаас хойш дээд хэмжээний харилцан айлчлал тогтмолжиж, хоёр талын харилцаа улс төр, цэрэг, худалдаа эдийн засгийн бүх салбарт эрчимжив.

-4290 км урт Орос-Хятадын хилийн демаркацийг тогтоож, хилийн зүүн болон баруун хэсэгт итгэлцлийг тогтоож, маргаантай зарим арлын асуудлыг түр хойш тавьж алгуур тайван шийдэхээр болов.

-Хил залгаа Хятадын мужууд, Оросын холбооны субъектуудын хооронд хамтын ажиллагааны зарчмыг тохиролцож хүн, бараа таваарын солилцоо асар ихээр өргөжив.

-Хятадын арми цэргээ дахин дахин хорогдуулж, Оросын тал ч Алс Дорнод дахь цэргээ хагас саяас 200 мянга хүртэл хорогдуулав. Хятадын арми Оросоос сөнөөгч нисэх онгоц, пуужин сөнөөгч зэрэг хамгийн орчин үеийн зэвсэг худалдан авах болов.

-Оросын тал Хятадын асар том зах зээлийг ихэд сонирхож газрын тос, цөмийн эрчим хүч, иргэний агаарын тээвэр зэрэг салбарт хэд хэдэн томоохон төслийг хэрэгжүүлэхээр харилцан тохиролцоод байна. Ялангуяа эрчим хүчний салбарт Орос нь нийлүүлэгч, Хятад нь хэрэглэгч гэсэн XXI зуунд чиглэсэн бие биеэ нөхсөн бүтэц бүрдэх төлөв нээгдээд байна.

Үүний цаана зөвхөн эдийн засгийн бус улс төр, стратегийн сонирхол байгаа нь тодорхой. "Хүйтэн дайны" дараа их гүрнүүдийн харьцаанд өөрчлөлт гарч АНУ цорын ганц "супер их гүрэн" болсон, НАТО дорно зүг өргөжин тэлж Оросын нөлөөний хүрээ хумигдсан, Хятад нь хүний эрх зэрэг асуудлаар Өрнөдтэй сөргөлдөхдөө ганцаардах болсон зэрэг хүчин зүйлүүд үйлчилж байна.

б/ Орос-Японы харилцаа нь 1997 оны 2-р хагасаас идэвхжиж хоёр тал газар нутгийн асуудлыг тойрсон мухардлаас гарах арга замыг хайж эхлэв. Энэхүү мухардмал байдлын уг сурвалж нь Курилийн 4 арлыг эзэмших эрх буюу япончуудын нэрлэдгээр "умард нутгийг" Оросоос буцаан авах асуудал болно. Японы тал Оростой энхийн гэрээ байгуулах урьдчилсан нөхцөл бол газар нутгийн асуудлыг эхлээд шийдвэрлэх хэмээн хатуу ярьж ирсэн.

Японы ерөнхий сайд Хашимото 1997 оны 7-р сард "итгэлцэл, харилцан ашигтай байх, урт хугацааны төлөв" гэсэн 3 зарчмын үндсэн дээр Оростой харилцах шинэ бодлогоо зарлав. Тэрээр Ельцинтэй уулзахаар 1997 оны 11-р сард Красноярскт айлчлав. Энэ нь Японы тал дайнаас хойш анх удаа Курилийн асуудлыг хойш тавьж эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхээр шийдсэнийг гэрчилж байна. Экспертүүд үүнийг гол нь Оросын Алс Дорнодын байгалийн баялагтай холбон үзэж байна. Ирэх 20 жилд Зүүн Азийн орнуудын эрчим хүчний эрэлтийн асуудлыг шийдэхийн тулд Оросын Сибирь, Алс Дорнодын газрын тос, байгалийн хийн асар том орд газруудыг эзэмшихэд хөрөнгө оруулалтыг хийж эрчим хүчний тогтвортой эх үүсвэртэй болох сонирхол Японд давамгайлсан нь тодорхой.

в/ "Хүйтэн дайны" дараах Евразийн газрын зурагт цоо шинээр зурагдсан улсууд нь Төв Азийн хэмээгдэх 5 орон болно. Нефть, хий зэрэг стратегийн чухал түүхий эдийн баялаг нөөц болон түүнийг ашиглахтай холбогдон Турк, Иран зэрэг олон улсын зүгээс улс төр, эдийн засаг, дипломатын чиглэлээр гаргаж буй идэвхи, өрсөлдөөнөөс харахад ирэх зуунд Төв Азийн орнууд нь Евразийн улс төр, эдийн засгийн нэгэн томоохон төв болох хэтийн төлөв ажиглагдаж байна.

Төв Азийн орнууд нь манай хоёр хөрш болох Орос, Хятадын хувьд эдийн засгийн төдийгүй улс төр, стратегийн ач холбогдолтой юм. Орос нь тэдгээр орнуудад амьдарч буй олон сая орос иргэдийн эрх ашгийг хамгаалахаас гадна Төв Ази болон Каспийн тэнгис хавийн нефть, хийн нөөц баялгийг ашиглах, тээвэрлэхэд урьдын нөлөө, газар нутгийн ойр байдлаа ашиглан давуу эрхтэй оролцож зонхилох байр сууриа хадгалахыг эрмэлзэж байна. Хятад нь өөрийн хамгийн тогтворгүй үндэсний район болох Шинжаанд Төв Азийн зүгээс гарч болзошгүй сөрөг нөлөөллөөс сэрэмжлэхийн хамт Төв Ази гэсэн түлш эрчим хүчний эх үүсвэртэй болохыг улам ч илүү чухалчилах болов.

## **2. ЗХА-ийн бүс нутгийн эрчим хүч, байгалийн хийн эрэлт нийлүүлэлтийн шинэ төлөв**

1986-1996 оны 10 жилийн хооронд дэлхийн эрчим хүчний нийлүүлэлт жилд дунджаар 2,6 хувиар өсч эрчим хүч хэрэглэгчдийн хувьд тогтвортой нийлүүлэлтийг хангаж чаджээ. Үүний шалтгаан нь эрчим хүчний үнэ өндөр байсандаа биш, харин технологийн хувьсгалын үр дүнд газрын тос /нефть олборлолтын зардал эрс буурчээ. Нөгөө талаас газрын тосны гол нийлүүлэгч Персын булангийн орнуудын нийлүүлэлт тун багаар нэмэгдэж, харин Норвег, Латин Америк зэрэг Өрнөдийг баримжаалсан шинэ нийлүүлэгчдийн үүрэг роль нэмэгдсэн байна.

Эрчим хүчний анхдагч эх үүсвэр нь газрын тос, байгалийн хий, нүүрс, усны болон цөмийн эрчим хүчнээс голчлон бүрэлддэг. Сүүлийн 10 жилд газрын тос энэ балансад эзлэх хувь 40 хувьд тогтвортой байж, харин байгалийн хийн эзлэх хувь 23 хувь болж өсөж, нүүрснийх 27 хувь болж бууран, усны болон цөмийн эх үүсвэр үлдэх 10 хувийг эзлэх болжээ. Өөрөөр хэлбэл Дэлхийн эрчим хүчний эх үүсвэрийн балансад байгалийн хийн эзлэх хувийн жин улам бүр өсөх хандлагатай байна. Байгалийн хий нь байгаль орчинд хор нөлөө багатай, ашиглах, тээвэрлэх, хадгалахад хялбар тохиромжтой.

Түүнчлэн ирэх 10-20 жилд дэлхийн газрын тосны эрэлт өсөхгүй, эсвэл тун ялихгүй өсөх, харин байгалийн хийн эрэлт илүү нэмэгдэх төлөвтэй байна. Дэлхийн хэмжээнд байгаль орчны хүчин зүйл, ялангуяа дэлхийн цаг агаар дулаарч /global warming/ байгалаас шалтгаалан газрын тосны эрэлт багаар өснө гэж үзэж байна. Европт ч тэр, Азид ч тэр шинээр бий болгох эрчим хүчний хүчин чадлыг газрын тосонд бус ихэвчлэн байгалийн хийнд түшиглэн хөгжүүлэх бололтой.

Ази-Номхон далайн бүс нутагт 1996 оны байдлаар 234 тэрбум шоо метр байгалийн хийг хэрэглэсэн нь Европ /251/, Америктай /658/ харьцуулахад бага байгаа юм. Нийт эрчим хүчний хэрэглээнд байгалийн хийн эзлэх хувийн жинг авч үзвэл Хойд Америкт 26 хувь, Европт 19 хувь байхад Ази Номхон далайд 9 хөн хувь байгаа юм. Гэхдээ Бритиш Петролеум-ын тооцоолсноор цаашдаа АНД-ын байгалийн хийн хэрэглээ бусад тивээс илүү хурдтай нэмэгдэж /жилд дунджаар 7 хувь/, 2010 онд бүс нутгийн хэрэглээ 2 дахин нэмэгдэж 470 тэрбум шоо метрт хүрэх тооцоо гарчээ.

Энэхүү өсөлтийн ихэнх нь цаашдаа байгалийн хийн голлох импортлогч орнууд болох Хятад, Энэтхэгт ноогдох бололтой. Түүнчлэн Өмнөд Солонгос, Тайваны байгалийн хийн хэрэгцээ хүчтэй өсөх, харин Япон, Австралийн эрэлт тогтвортой нэмэгдэх төлөвтэй байна.

а/ ЗХА-ийн орнуудын байгалийн хийн эрэлт ойрын 10-20 жилд нэлээд нэмэгдэх төлөвтэй байна. Японы ХАҮЯ-ны Эрчим хүчний судалгааны Зөвлөлөөс хийсэн судалгаанаас үзвэл Азийн орнуудын /үүнд Япон, Хятад, Тайван, Өмнөд Солонгос ба АСЕАН-ы 6 орон багтаж байна/эрчим хүчний хэрэглээ 1992 оноос 2010 оны хооронд жилд дунджаар 3,9 хувь, түүн дотор байгалийн хийн хэрэглээ 5,9 хувиар өснө гэж тооцоолжээ. Хэрвээ эдгээр Азийн орнууд 1992 онд газрын тосны импортынхоо 55 хувийг гаднаас их төлөв Ойрхи Дорнодоос, байгалийн хийн 9 хөн хувийг гаднаас авч байсан бол 2010 онд газрын тосныхоо 70 хувийг, байгалийн хийн 27 хувийг гаднаас авах ажээ. Өөрөөр хэлбэл Ойрхи Дорнодын газрын тос болон гаднын импортын байгалийн хийгээс хамаарах хамаарал ихээхэн нэмэгдэх төлөвтэй.

Хятад нь 1993 оноос эхлэн газрын тос импортлогч орон болж хувирсан бөгөөд түүний газрын тосны импорт 1995-2020 оны хооронд жилд дунджаар 4,4 хувиар өсөх тооцоо гарчээ. Нэгэн зэрэг Хятадын байгалийн хийн хэрэгцээ ирэх 25 жилд дунджаар 9,2 хувиар өсөж түүний Хятадын нийт эрчим хүчний балансад эзлэх хувь 1995 онд дөнгөж 1,9 хувь байсан бол 2020 онд 7 хувь болж өсөх төлөвтэй байна. Гэвч 2005 он хүртэл Хятад байгалийн хийн эрэлтийнхээ их төлөвийг дотоодын үйлдвэрлэлээр хангах зорилт тавьж байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Японы эрчим хүчний эх үүсвэрийн балансын нэг онцлог нь газрын тос 55 хувийг эзэлдэг бөгөөд түүний 70-80 хувийг Ойрхи Дорнодоос импортлож байна. Цаашдаа Японы газрын тосны эрэлт харьцангуй багасах, харин байгалийн хийн эрэлт нэмэгдэх төлөвтэй. 2020 он хүртэл Японы газрын тосны хэрэглээ жилд дунджаар 0,4 хувь өсөх бол байгалийн хийнх 4,3 хувиар өсөх тооцоо гарчээ. Япон нь өнөөдөр байгалийн хийн хэрэгцээнийхээ ихэнхийг Австрали, Индонез, Малайзаас шингэрүүлсэн хийн хэлбэрээр танкераар зөөж хангаж байна.

Өмнөд Солонгос ч мөн Японтой адил газрыг тосноос 60 хувь хамааралтай түүнийхээ 70 орчим хувийг Ойрхи Дорнодоос авдаг байна, Өмнөд Солонгос нь 1986 оноос эхлэн шингэрүүлсэн байгалийн хийг гаднаас

авч эхэлсэн бөгөөд өнөөдөр тэр нь түүний эрчим хүчний балансад 5 орчим хувийг эзэлж байна. Цаашдаа газрын тосны импортыг хязгаарлаж, харин байгалийн хийн импортыг 2010 он гэхэд одоогийнхоос 3 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

б/ ЗХУ-ын орнуудын байгалийн хийн нийлүүлэлт өнөөдөр их төлөв ЗӨА-ийн орнууд Индонез, Малайз, Брунейн зүгээс шингэрүүлсэн хийн импортаар /LNG/ хангагдаж байна. Цаашдаа Ойрхи Дорнод, мөн хуучин ЗХУ /үүнд Оросын Алс Дорнод, Сибирь, Төв Азийн орнууд багтаж байна/ гэсэн хоёр томоохон нийлүүлэгч гарч ирэх төлөвтэй байна. ЗХА-ийн орнууд эрчим хүчнийхээ эх үүсвэрийг олон талтай болгох, Ойрхи Дорнодоос хэт хамааралтай болох явдлаас сэрэмжлэхийн тулд хуучин ЗХУ-ын нутгаас байгалийн хий импортлах сонирхол нэмэгдэж байна.

Байгалийн хийн томоохон ордууд гэвэл:

-Сахалины газрын тос ба байгалийн хийн нөөц нь Пилтун-Астохское болон Лунское гэсэн хоёр ордод төвлөрч байна. Сахалин II гэсэн төслийг АНУ-ын Марасон, Европын Шелл, Японы Мицуй, Мицубиши пүүсийн хамтарсан олон улсын консорциум хэрэгжүүлж буй бөгөөд нийт хөрөнгө оруулалт нь 10 тэрбум ам доллар байх тооцоо гарчээ. Газрын тосны олборлолтыг 1999 оны 7-р сараас, шингэрүүлсэн хийн олборлолтыг 2005 оноос эхлэхээр төлөвлөжээ. Японы Экспорт-Импортын банкнаас энэ төслийн эхний ээлжинд зориулан 16 сая ам долларын зээллэг олгохоор шийдсэн байна. Энэхүү Сахалины төсөл нь бүтээгдэхүүн хуваах зарчмаар хийгдсэн Оросын анхны төсөл гэсэн утгаараа их анхаарал татаж байна.

-Туркменистаны байгалийн хийн нотлогдсон нөөц нь 2,8 триллион шоо метр бөгөөд нөөцийн хэмжээг 8,1 триллионд хүргэх боломжтой гэж үздэг. Туркменистанаар байгалийн хийг Иран, Туркээр дамжуулан Европт, Афганистанаар дамнуулан Пакистанд хүргэх хоёр ч шинэ хийн хоолойн төсөл хэрэгжих шатандаа байгаагаас гадна Туркменистан-Хятад-Япон гэсэн 28 тэрбум шоометрийн хүчин чадалтай хийн хоолойн төсөл идэвхтэй яригдаж байна.

-Сахагийн /хуучин нэрээр Якутск 17 орд газрын нөөц ойролцоогоор 17 триллион шоо метр бөгөөд Саха-Сахалин-Вакканай/ гэсэн 2950 км урт 20 тэрбум шоо метрийн хүчин чадалтай хийн хоолойг Япон хүртэл татах төсөл яригдаж байна.

-Иркутскийн ойролцоох Ковыктагийн орд одоогоор 860 тэрбум шоо метр байгалийн хийн нотлогдсон нөөцтэй. Хайгуулын ажлыг үргэлжлүүлж нөөцийн хэмжээг 1,5 триллион шоо метрт хүргэх боломжтой гэж үздэг.

в/ ЗХА-ийн орнууд байгалийн хийн хэрэгцээгээр үндсэн хоёр аргаар: байгалийн хийг шингэрүүлж танкераар тээвэрлэх, мөн байгалийн хий дамжуулах хоолой барих аргаар хангах боломжтой. Байгалийн хийг 5000 7000 км-аас богино зайд тээвэрлэхэд хийн хоолой эдийн засгийн үр ашиг илүүтэй гэж үздэг бол 5000-7000 км-ээс хол зайд тээвэрлэхэд шингэрүүлж

танкерээр тээвэрлэх нь үр ашигтай гэж үздэг байна.

Өнөөдрийн байдлаар Европт 800 мянган км урт, АНУ-д 440 мянган км урт байгалийн хийн хоолой ашиглагдаж байна. Харин Азид Малайз-Сингапурын хоорондох хоолойг эс тооцвол үндсэндээ хийн хоолой хөгжөөгүй гэж хэлж болно.

Японы Мицубиши судалгааны хүрээлэнгээс Хойд Сахалин, Саха, Иркутск болон Туркменистаны байгалийн хийн ордуудаас хийн хоолой татаж Хятад, Өмнөд Солонгос, Японы хэрэгцээг хангах судалгааг явуулсан байна.

Тэдгээр хийн хойлойг А, Б, В, Г гэсэн 4 хувилбараар авч үзсэн байна.

-А хоолой: Ашхабад- Өрөмч- Ланьжоу-Сиань, Ляньюнган-Мокло-Китакюшю.

-Б хоолой: Саха-Аян-Сахалин-Вакканай чиглэлээр

-В хоолой: Эрхүү-УБ-Бээжин-Шэньян Пхеньян-Сеул-Пусан-Китакюшю чиглэлээр

#### **Төлөвлөж буй хийн хоолойнууд**

Чиглэл	А	Б	В	Г
Эх үүсвэр	Ашхабад	Эрхүү	Эрхүү	Саха
Хүрэх боомт	Китакюшю	Китакюшю	Китакюшю	Китакюшю
Урт км	7475	4870	4635	2950
Багтаамж тэрбум шоо метр/жилдээ	20	10	10	10
Барих өртөг сая ам.дол	22550	14410	13280	9950

**Эх сурвалж: National Pipeline Research Society of Japan**

### **3. Эрхүүгийн төслийн талаарх ОХУ, Хятад,**

#### **Японы байр суурь**

а/ Хятадын байр сууриас цаашдын 20 жилийн Азийн эрчим хүчний баланс ихээхэн хамаарах нь гарцаагүй. Хятад нь нэгд: өөрийн эрчим хүчний анхдагч эх үүсвэрт тулгуурлах, хоёрт: Нүүрсээр эрчим хүчнийхээ 70-80 хувийг хангах бодлого явуулж ирсэн билээ. Хэдийгээр нүүрсний эзлэх хувь ойрын ирээдүйд өндөр хэвээр үлдэх боловч газрын тос, байгалийн хийн хэрэглээ түргэн хурдтай өсөх төлөвтэй байна.

Хятадын эрчим хүчний бодлого нь цаашид улам нэмэгдэх газрын тос, байгалийн хийн импортыг хангахын тулд гадагшаа чиглэсэн идэвхтэй бодлого явуулж импортынхоо эх үүсвэрийг аль болох олон талтай болгоход

чиглэж байна. "Фар Истерн Экономик Ревью" сэтгүүлд бичсэнээр 1997 онд Хятадын Үндэсний Газрын тосны корпарац1 /China National Petroleum Corporation/ Хятадын Үндэсний Газрын тосны корпорац нь төрийн өмчийн бөгөөд, 1,7 сая ажиллагсадтай, 25 газрын түүхий тос боловсруулах үйлдвэртэй томоохон корпорац болно. Мөн түүний харъяанд 9 их дээд сургууль, 279 судалгааны хүрээлэн газар багтдаг байна. Уг корпорацийн орлого нь 1997 оны байдлаар 21 тэрбум ам. доллар гэж экспертүүд тооцжээ. 1996 оны сүүлчээр корпорацийн удирдлагад халаа гарч Чжоу Ёнкан ерөнхийлөгч болжээ. Судан, Венесуэл, Ирак, Казахстан зэрэг оронд газрын тосны орд газрыг худалдан авахаар 8 тэрбум ам.дол.-ын амлалт хийж, Төв Ази болон Оросоос Хятад руу нийтдээ газрын тос, байгалийн хийг тээвэрлэх 4 ч хоолой барихаар 12,5 тэрбум ам. дол-ын хөрөнгө оруулалтын амлалт авчээ.

Тухайлбал, Хятадын тал 1997 оны 6-р сард Казахстаны газрын тосны томоохон компани болох Актюбинскмунай-н хувьцааны 60 хувийг 4,3 тэрбум ам. дол-аар худалдан авсан байна. Ингэснээр Хятад нь Казахстаны асар их газрын тосны нөөцийг олзворлох, ашиглахад оролцохоос гадна тэндээс Шинжаан хүртэл дамжуулах хоолой барихаар зэхэж байна. Экспертүүдийн үзэж байгаагаар Хятадаас Казахстаны компанид хийсэн хөрөнгө оруулалт нь зөвхөн эдийн засаг, эрчим хүчний төдийгүй үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс хийгдсэн гэж үзэж байна. Дамжуулах хоолойн барилга байгууламж нь Хятадын хамгийн тогтворгүй үндэсний район болох Шинжаанд ажлын байрыг ихээр нэмэгдүүлснээр тэндэх үндэсний үзэгний байр суурийг сулруулах зорилготой байж болно.

Эдгээр бүх хөрөнгө оруулалт нь Хятадын газрын тосны нийлүүлэлтийг удаан хугацаанд тогтвортой хангах үндэсний стратегид нийцэж байгаа нь тодорхой. Хятадын төрийн бодлогын хэмжээнд "газрын тосны нийлүүлэлтийн аюулгүй байдлыг хангах систем бий болгохыг чухалчилах болов. Өөрөөр хэлбэл, газрын тосны эх үүсвэрээ аль болох олон болгосноор ямар нэг экспортлогч орон олон улсын зүгээс хориг тавиулах эсвэл аль нэг чухал зам харилцаа хаагдахад үүнд өртөхгүй байх систем болно.

Хятадын ийнхүү эрчим хүчний аюулгүй байдлаа бие даан хангах гэсэн бодлого, үйл ажиллагаа нь газрын тосны глобал сонирхолтой орнууд болох АНУ болон Оросын ашиг сонирхлыг тодорхой хэмжээгээр хөндөх болов. Ялангуяа, Хятадын тал газрын тосоор баян Иран, Ирактай хамтран ажиллахыг чармайж байгаа нь тэднийг эдийн засгийн хувьд ганцаардуулах бодлого явуулдаг Америкын бодлоготой зөрчилдөж байна. Хятадын тал Иракт газрын тосны ордыг бүтээгдэхүүн хуваагдах зарчмаар эзэмших гэрээ хийснээс гадна Казахстанас Иранаар дамжуулан газрын тос тээвэрлэх хоолой барих гэрээ хийжээ.

Хятадын тал мөн Казахстанд ихээхэн хөрөнгө оруулалт хийж Казахстанас Шинжаан хүртэл газрын тос татахыг төлөвлөж байгаа нь Төв Азид хуучин давамгайл эрх ашгаа хадгалах, тэднээс гарах газрын тос, хийн

хоолойн гарцыг хяналтандаа байлгах гэсэн Оросын эрх ашигтай зөрчилдөх болов. Казахстаны хувьд Хятадтай шууд харьцан хамтран хоолой татах нь өөрийн гэсэн бие даасан гадаад бодлогын нэгэн томоохон илэрхийлэл болох юм.

Нөгөө талаар Оросын тал XXI зуунд өөрийн Сибирь болон Алс Дорнодын эрчим хүчний анхдагч эх үүсвэрийн томоохон импортлогч болох төлөвтэй Хятадыг чухалчлан үзэж байгаа нь тодорхой. Энэ ч үүднээс Оросын тал Эрхүүгийн ойролцоох Ковыктагийн байгалийн хийн ордыг хамтран эзэмших, тэндээс Хятад, цаашилбал Япон хүртэл хийн хоолой тавихыг Хятадад санал болгосон нь тодорхой. Өөрөөр хэлбэл, Ковыктагийн орд нь Туркменистаны ордыг бодвол Хятадад хамаагүй ойрхон, хийн хоолойн өртөг зардал нь хямд төсөр болох юм.

Хятадын хувьд Ковыктагийн байгалийн хий нь байгаль орчны үүднээс бас их ач холбогдолтой юм. Хятадын Зүүн хойд хэсэгт асар их нүүрс шатаадгаас болж Өмнөд Солонгос, Япон зэрэг хөрш орнуудын хувьд агаар бохирдох /acid rain/ гол шалтгийн нэг болж сүүлийн жилүүдэд энэ чиглэлээр Хятадын тал улам бүр шахалтанд орох болжээ. Нүүрсийг байгалийн хийгээр орлуулснаар өөрийн орны төдийгүй хөрш орнуудын байгаль орчныг цэвэршүүлэх боломжтой болох юм.

б/ Орос нь 10 жилийн өмнө Дэлхийн хамгийн том газрын тосны үйлдвэрлэгч байв. ЗХУ задарснаас хойш газрын тосны үйлдвэрлэл асар ихээр хорогджээ. Зөвлөлтийн газрын тосны монополийн суурин дээр хэд хэдэн томоохон хагас хувьчлагдсан компаниуд бий болов. 11 Вагит Алекперовын толгойлсон ЛУКойл компани нь жилд дунджаар 60 сая гаруй тонн нефть олборлодог бөгөөд Оросын рейтингт 1-рт ордог. Түүний гол сонирхол нь Азербайжан, Казахстан, Туркменистан зэрэг Каспийн тэнгисийн нөөц болон Оросын өмнөд районуудад төвлөрдөг байна. 1998 оны 1-р сард ЮКОС, Сибнефть, зэрэг 4 компани нэгдэн ЮКСИ хэмээх шинэ хүчирхэг холдинг байгуулжээ. ЮКСИ-д нэгдсэн компаниуд 1997 онд 65 сая тонн нефть олборлож Оросын бүх олборлолтын 22 хувийг эзэлжээ. ЮКСИ-ийн ерөнхийлөгчөр Михайл Ходорковский болжээ. Хэдий тийм ч Орос нь байгалийн хийн Экспортоор дэлхийд тэргүүлэх байраа хадгалсан хэвээр байна. Орос нь 1995 онд 300 сая тонн нефть олзворлож, 178 саяыг боловсруулж, 120 сая тонныг экспортод гаргасан байна. Оросын газрын тос, байгалийн хийн комплекс нь нийт улсын төсвийн 40 орчим хувийг бүрдүүлж, гадаад валютын орлогын 50 орчим хувийг хангадаг байна.

Оросын газрын тос, байгалийн хий нь өмнө нь Дундад Ази, Дорнод Европын орнуудад ихэвчлэн экспортлахад зориулагдаж байв. Өнөөдөр байдал эрс өөрчлөгдөж Дорнод Европ, Дундад Азийн орнууд урьдын ач холбогдлоо алджээ. 1995 оны байдлаар Дорнод Европын орнуудад "Найрамдал" газрын тосны хоолойгоор Оросын газрын тосны экспортын 30 хувийг экспортлосон бөгөөд нийт ТУХН-ын орнууд /ближнее зарубежье/

Оросын эзспортын 20 хон хувийг шингээсэн байна.

Каспийн тэнгис, түүний эрэг хавийн орнууд Казахстан, Азербайжан, Туркменистан ирэх зуунд газрын тос, байгалийн хийн дэлхийн томоохон Төв болох бүх боломж бүрджээ.

Асуудлын гол гогцоо нь энэ их баялгийг хэрхэн дэлхийн зах зээлд гаргах вэ гэдэг асуудал болно. Тиймээс ч Оросын тал энэ их нөөцийг эзэмшихэд давамгайлан оролцох, түүнчлэн түүнийг өөрийн нутгаар өөрийн усан боомтоор дамжуулан дэлхийн зах зээлд гаргахын төлөө бүхий л бололцоотой хөшүүргээ ашиглан ажиллах болов.

Орос Алс Дорнод, Сибирийн газрын тос, байгалийн хийн асар их нөөцийг Ази, ялангуяа Зүүн Хойд Азийн орнуудад экспортлох асуудал 1990-ээд оны дундаас эхлэн идэвхтэй яригдах болов. Үүнд улс төр, геостратеги, эдийн засгийн бүхий л хүчин зүйлүүд нааштай үйлчлэх болов. Хүйтэн дайн төгсгөл болж Оросоос Хятад, Өмнөд Солонгос, Японтой хоёр талын харилцаа тус бүр хэвийн болж улс төрийн таатай нөхцөл бүрдэж байна. Хятад зэрэг орны эдийн засаг өндөр хурдтай хөгжиж тэдгээр орны эрчим хүчний эрэлт улам бүр нэмэгдэх болов.

Хэрвээ Оросын ерөнхийлөгч Ельцин 1996 оны 4-р сард Бээжинд айлчих үед Оросын сонинд "Орост Хятад ямар хэрэгтэй вэ" /Зачем Россия Китай/ гэж бичиж байсан бол түүний 1997 оны 11-р сард хийсэн айлчлалын үеэр Хятадын ач холбогдолд хэн ч эргэлзэхээ больж Оросын хувьд "дипломат бодлогын зүүн вектор нь баруун вектортайгаа ав адилхан" гэж ярих болжээ. 21-р зуунд чиглэсэн Орос-Хятадын "стратегийн түншлэлийн" гол салбарууд нь газрын тос, цөмийн эрчим хүч, иргэний агаарын тээвэр гэж тодорхойлжээ.

Оросын тал Эрхүү орчмын Ковыктагийн байгалийн хийн ордыг ашиглах, тэндээс байгалийн хийг Монголоор дамжуулан Хятадад хийн хоолойгоор экспортлох төсөлд ихээхэн ач холбогдол өгөх болов. В.Черномырдины Бээжинд 1997 оны 6-р сард хийсэн айлчлалын үеэр хоёр тал газрын тос, байгалийн хийн салбарт, түүн дотор Ковыктагаас Хятадын Шаньдун мужийн Жижао боомт хүртэл байгалийн хий дамжуулах хоолой барих төслөөр хамтран ажиллах зарчмын тохиролцоонд хүрчээ. Б.Ельциний БНХАУ-д 1997 оны 11-р сард хийсэн айлчлалын үеэр "ОХУ-ын Дорнод Сибирийн бүс нутгаас БНХАУ болон гурав дахь орны хэрэглэгчдэд байгалийн хий дамжуулах хоолой барих Ковыктагийн орд газрыг ашиглах төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах үндсэн зарчмын тухай ОХУ, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Меморандум"-д гарын үсэг зуржээ.

ОХУ-ын газрын тосны "Сиданко" компани 1 Сиданко нь жилд дунджаар 25 сая тонн нефть олзворлодог бөгөөд Оросын газрын тосны рейтингт 4-р байр эзэлдэг байна. Сиданко нь Владимир Потанины толгойлсон ОНЭКСИМ банкын группт харъяалагддаг байна. Сиданко нь Ковыктагийн орд газрыг эзэмших лицензийг гартаа хийсэн "Русиа Петролеум" компанийн хувьцааны 60 хувийг эзэмшдэг учир энэхүү

Ковыктагийн төслийн Оросын талын гол тоглогч болж гарч ирсэн юм. Британийн "Бритиш Петролеум" компани Сиданко компанийн хувьцааны 10 хувийг ОНЭКСИМ банкнаас худалдан авч, мөн Руся Петролеум компанийн хувьцааны 45 хувийг Сиданко компаниас худалдан авсан байна. Түүнчлэн Роснефть компанийг хувьчлах явцад Би Пи нь ОНЭКСИМ, Сиданкотай хамтран эвсэл байгуулж нөгөө нэг Газпром, Шелл, ЛУКОЙЛ эвсэлтэй өрсөлдөхөөр болж байна. 1996 онд Хятадын үндэсний газрын тосны корпорацийн мэргэжилтнүүдтэй хамтран Ковыктагаас Монголоор дамжуулан Жижао боомт хүртэл барих 3360 км урт хийн хоолойн техник эдийн засгийн урьдчилсан тооцоог хийж гүйцэтгэсэн байна. Тэдний тооцооноор уг төслийг хэрэгжүүлэхэд 7 орчим тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хэрэгтэй ажээ. Уг хийн хоолойг 2004 он гэхэд ашиглалтад өгөхөөр тооцоолсон бөгөөд жилдээ 20 тэрбум шоо метр хий шахахаас 70 тэрбумыг Хятад хэрэглэж үлдэх хэсгийг Өмнөд Солонгос, Японд цааш нь экспортлахаар тусгажээ.

в/ Япон нь газрын тосны импортынхоо хувьд Ойрхи Дорнодоос багагүй харин улам ч ихсэх төлөвтэй. Японы газрын тосны импортын Ойрхи Дорнодоос хамаарах хамаарал нь 1995 онд 78,6 хувь байсан бол 2000 онд 82,0 хувь, 2010 онод 90,0 хувь болж өснө гэж тооцож байна. 1970-аад оны нефтийн хямрал болон 1990 оны Персийн булангийн хямралын үеэр газрын тосны нийлүүлэлт тасалдаж, эрчим хүчний үнийн өсөлт авчирч байсан. Тиймээс ч Япон мэтийн өөрийн газрын тосгүй орнууд эрчим хүчийг хэмнэх, газрын тосыг өөр эх үүсвэрээр оруулах, газрын тосны стратегийн нөөцтэй болох зэрэг бодлогыг авч хэрэгжүүлснээс гадна Ойрхи Дорнодын импортаас хамаарах хамаарлаа аль болох багасгах арга замыг хайх болов.

Японы Дотоодын эрчим хүчний балансыг аваад үзвэл 1995 оны байдлаар газрын тос 55,8 хувь, нүүрс 16,5 хувь, байгалийн хий 10,8 хувийг эзэлж байгаа бөгөөд 2010 он гэхэд газрын тосны хувийн жинг 50 хувь хүртэл нэмэгдүүлэх бодлого барьж байна. Өнөөдөр Япон байгалийн хийгээ Индонез, Малайз, Бруней зэрэг орноос шингэрүүлсэн хэлбэрээр татаж авч байна. Цаашдаа Ойрхи Дорнодоос хэт хамааралтай байдлыг өөрчлөх явдал нь Японы эрчим хүчний аюулгүй байдлыг хангах нэг чухал арга зам гэж яригдах болжээ.

Энэ ч үүднээ Японоос 2000-4000 км ойр зайд орших Оросын Алс Дорнод, Зүүн Сибирийн газрын тос, байгалийн хийн асар баялаг орд газрыг хамтран ашиглах, тэндээс Японд хүртэлхийн хоолой татах асуудлыг цаашдын Японы эрчим хүчний аюулгүй байдлыг хангах нэг хувилбар гэж тавих болов. Ингэснээр нэгд, Япон, Тайван, Өмнөд Солонгос зэрэг Зүүн Азийн орнуудын хувьд эрчим хүчний бас нэг найдвартай эх үүсвэртэй болж Ойрхи Дорнодоос хэт хамааралтай байдлыг саармагжуулж чадна гэж үзэж байна. Цаашилбал, Оросын Алс Дорнодын байгалийн баялгийг эзэмшихэд Японы талын хөрөнгө оруулалтыг хийснээр Япон-Оросын харилцааг зогсонги байдлаас гарган яваандаа Курилийн арлын газар нутгийн асуудлыг ч Японд ашигтай

хувилбараар шийдэхэд хөрс суурь бэлтгэж өгнө гэж үзэж байна.

Нөгөө талаас Японы эрчим хүчний "крантыг хаах" эрхийг Оросын тал авчихна гэсэн бүр Брежневийн үеэс гаралтай улс төрийн болгоомжлол хардлага өнөө ч Японд хүчтэй хэвээр байна. Өөрөөр хэлбэл, Оросоос их хэмжээний байгалийн хий авч ашиглах нь тэдэнд Японы эрчим хүчний аюулгүй байдалд нөлөөлөх боломж олгоно гэсэн сөрөг саналыг Японы зарим улс төрийн зүтгэлтнүүд тавьж байгаа юм. Түүнчлэн Сибирь болон Монголын зэлүүд газар нутгийг дайруулан хийн хоолой татах ажилд Япончууд тийм их хөрөнгө хаях нь утгагүй хэрэг гэж үздэг Японы засгийн газрын гишүүд ч бий.

**Өмнөд Солонгос XXI зууны  
Япон мөн үү**

*Дэд доктор Д.УЛАМБАЯР (ОУХДС)*

**1. Хөгжлийн загвар**

Хүн төрөлхтөн өнөөгийн ирмүүн хөгжлийн өндөрлөгт тулж ирэхдээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн үр ашиг бүхий хэд хэдэн загварыг бүтээн бий болгожээ.

НЭГДЭХ нь Өрнө дахины хөгжингүй орнуудын загвар бөгөөд энэ нь 1640-оны Английн Хөрөнгөтний аугаа их хувьсгалаар гараагаа эхэлж, 1776 оны Америкийн Тусгаар тогтнолын Тунхаглал, 1787 оны Америкийн Анхдугаар Үндсэн Хууль, 1789 оны Францын Хөрөнгөтний Их Хувьсгал түүний үр дүнд батлагдсан Хүн ба Иргэний Эрхийн Түгээмэл Тунхаглал, 1865 онд ялсан Америкийн Хөрөнгөтний Хувьсгалаар бэлтгэгдэж өнөөг хүрч ирсэн буюу УЛС ТӨРИЙН АРДЧИЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ДЭЭР ЭДИЙН ЗАСГИЙН АРДЧИЛАЛЫГ хөгжүүлж ирсэн загвар юм. Энэ нь бараг 20 гаруй жилийн түүхэн хөгжлөөр бий болжээ. ХОЁР ДАХЬ ГЭЖ ХЭЛЖ болох Скандинавийн хойгийн орнуудын хөгжлийн загвар бол НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ төвдөө тавьж УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН АРДЧИЛАЛЫГ хөгжүүлж ирсэн загвар билээ. Энэхүү загвар энэ зууны эхээр бэлтгэгдэж Дэлхийн II дайны дараа эрч хүчээ авч өнөөг хүрч ирсэн байна. Хөгжлийн ГУРАВ ДАХЬ загвар бол Азийн шинээр аж үйлдвэржсэн орнуудын туршлага билээ. Сүүлийн гурван 10 жилд буй болсон энэ загвар нь ЭДИЙН ЗАСГИЙН АРДЧИЛАЛЫГ хөгжүүлэх үндсэн дээр УЛС ТӨРИЙН АРДЧИЛАЛЫГ хөгжүүлж иржээ. Азийн шинээр аж үйлдвэржсэн гэх Өмнөд Солонгос, Сингапур, Тайван, Гонконг зэрэг орнууд зах зээлийн эдийн засгийг төрийн хүчтэй зохицуулалтай хослуулжээ. Үнэхээр ч сайхь